



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Хэрлэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДОА-2025/145/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Чойбалсан хот 2025 он</p>	<p>Дорнод аймаг дахь Төрийн аудитын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 7058-4203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: И.Сэмжидмаа Утас: 7058-4207 Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Нармандах Утас: 7058-4207 Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Хаан консалтинг аудит ХХК Гүйцэтгэх захирал: Э.Нандинчимэг Утас: 88883776 Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2025.02.24 № 219
танай 2025.01.24 -ны № 1/3 -г

ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН
1 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Г.БАДРАА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Хэрлэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

Аудитын гол асуудал

Тайлант жилд нийгмийн даатгалын систем шинэчлэгдэж, төрийн алба хаагчдын цалингийн нэгдсэн системд ажил мэргэжлийн код болон даатгуулагчийн кодыг зөрүүтэй оруулснаас ажилтнаас илүү дутуу шимтгэл суутгах, байгууллагаас төлөх шимтгэлийн хэмжээг илүү дутуу тооцоолсноос шалтгаалан жилийн эцэст авлага, өр төлбөр үүсэж тайланд залруулгууд хийгдсэн байна.

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаагчид бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

011022045

Бусад асуудлын хэсэг

Дорнод аймгийн Хэрлэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилго, 5 зорилт, 53 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг аймгийн Боловсролын газраас 90.0 хувьтай үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	209,402,441.55	357,147,504.53
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	93,204,217.94	200,586,457.08
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	93,204,217.94	200,586,457.08
31211	Төрийн сангийн харилцах	93,204,217.94	200,586,457.08
33	АВЛАГА	360,955.80	
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	360,955.80	
35	БАРАА МАТЕРИАЛ	115,837,267.81	156,561,047.45
351	Түүхий эд материал	608,900.00	1,253,500.00
35130	Эм боох материал	608,900.00	1,253,500.00
354	Хангамжийн материал	115,228,367.81	155,307,547.45
35410	Бичиг хэргийн материал	874,500.00	1,715,500.00
35420	Аж ахуйн материал	2,125,000.00	9,240,000.00
35470	Бусад хангамжийн материал	112,228,867.81	144,352,047.45
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,233,007,313.48	2,219,933,058.94
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,233,007,313.48	2,219,933,058.94
392	Биет хөрөнгө	2,100,282,313.48	2,087,208,058.94
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,014,114,310.80	2,014,114,310.80
39202	Хуримтлагдсан элэгдэл	(138,714,194.44)	(183,753,813.16)
39214	Бусад үндсэн хөрөнгө	173,164,512.20	173,164,512.20
39204	Хуримтлагдсан элэгдэл	(32,703,789.88)	(47,461,705.12)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	95,908,256.00	145,058,820.10
39206	Хуримтлагдсан элэгдэл	(42,355,697.12)	(47,455,299.20)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	57,225,025.10	62,805,225.80
39208	Хуримтлагдсан элэгдэл	(26,356,109.18)	(29,263,992.48)
393	Биет бус хөрөнгө	132,725,000.00	132,725,000.00
39301	Програм хангамж	1,395,700.00	1,395,700.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,395,700.00)	(1,395,700.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	132,725,000.00	132,725,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,442,409,755.03	2,577,080,563.47
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	360,955.80	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	360,955.80	-
413	Өглөг	360,955.80	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	360,955.80	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,442,048,799.23	2,577,080,563.47
51	Засгийн газрын хувь оролцоо	2,442,048,799.23	2,577,080,563.47
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	408,530,130.97	408,530,130.97
51101	Өмч: - төрийн	408,530,130.97	408,530,130.97
512	Хуримтлагдсан үр дүн	1,567,815,678.34	1,702,847,442.58
51210	Өмнөх үеийн үр дүн	1,567,815,678.34	1,567,815,678.34
51220	Тайлант үеийн үр дүн	-	135,031,764.24
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	465,702,989.92	465,702,989.92
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,442,409,755.03	2,577,080,563.47

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	932,948,717.00	1,269,892,654.10
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	52,939,817.00	97,380,054.10

Дорнод аймгийн Хэрлэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

120	Нийтлэг татварын бус орлого	52,939,817.00	97,380,054.10
	Төсөв байгууллагын өөрийн орлого	25,331,740.00	71,569,158.10
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		1,111,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого/ үндсэн хөрөнгө/	25,331,740.00	70,458,158.10
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан / бараа материал	27,608,077.00	25,810,896.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	880,008,900.00	1,172,512,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	841,979,300.00	1,132,546,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		2,900,000.00
1320	Орон нутгийн төсвөөс сөнхүүжих	38,029,600.00	37,066,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	868,414,498.09	1,134,860,889.86
21	УРСГАЛ ЗАРДАЛ	868,414,498.09	1,134,860,889.86
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	843,883,330.15	1,133,561,012.72
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	516,160,381.27	746,654,070.00
210101	Үндсэн цалин	373,393,383.27	508,163,051.00
210102	Нэмэгдэл	124,378,371.00	211,220,717.00
210104	Урамшуулал	18,388,627.00	27,270,302.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	64,924,773.89	92,914,790.86
210201	Тэтгэврийн даатгал	44,572,237.56	64,471,408.64
210202	Тэтгэмжийн даатгал	5,287,421.81	7,778,034.91
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,602,255.01	3,761,969.37
210204	Ажилгүйдлийн даатгал	958,997.03	3,380,674.34
210205	Эрүүл мэндийн даатгал	9,503,862.48	13,522,703.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,051,532.06	34,166,522.86
210301	Гэрэл, цахилгаан	6,658,211.87	6,699,414.84
210302	Түлш, халаалт	18,502,938.19	18,872,186.02
210303	Цэвэр, бохир ус	7,890,382.00	8,594,922.00
210408	Бараа материал акталсны зардал	20,461,947.60	15,284,216.36
210502	Хоол, хүнс	115,045,425.00	129,278,600.00
210604	Урсгал засвар	-	1,600,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,344,234.00	1,215,000.00
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээ	1,344,234.00	1,215,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	92,895,036.33	112,447,812.64
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,457,371.93	17,656,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,415,800.00	11,258,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	77,021,864.40	83,532,412.64
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24,531,167.94	1,299,877.14
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	20,253,100.00	-
2134	Орон нутгийн төвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас санхүүжилт		1,299,877.14
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,478,067.94	1,299,877.14
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	64,534,218.91	135,031,764.24
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	64,534,218.91	135,031,764.24

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	880,008,900.00	1,172,512,600.00
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	880,008,900.00	1,172,512,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	841,979,300.00	1,132,546,200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	2,900,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /Орон нутгийн төсөвт байгууллага/	38,029,600.00	37,066,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	780,545,086.09	1,065,130,360.86
21	УРСГАЛ ЗАРДАЛ	780,545,086.09	1,065,130,360.86
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	756,013,918.15	1,063,830,483.72
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	516,160,381.27	746,654,070.00
210101	Үндсэн цалин	373,393,383.27	508,163,051.00
210102	Нэмэгдэл	124,378,371.00	211,220,717.00
210103	Урамшуулал	18,388,627.00	27,270,302.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	64,924,773.89	92,914,790.86
210201	Тэтгэврийн даатгал	44,572,237.56	64,471,408.64
210202	Тэтгэмжийн даатгал	5,287,421.81	7,778,034.91
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,602,255.01	3,761,969.37
210204	Ажилгүйдлийн даатгал	958,997.03	3,380,674.34
210205	Эрүүл мэндийн даатгал	9,503,862.48	13,522,703.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,051,532.06	34,166,522.86
210301	Гэрэл, цахилгаан	6,658,211.87	6,699,414.84
210302	Түлш, халаалт	18,502,938.19	18,872,186.02
210303	Цэвэр, бохир ус	7,890,382.00	8,594,922.00
2105	Нормативт зардал	115,045,425.00	129,278,600.00
210502	Хоол хүнс	115,045,425.00	129,278,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	1,600,000.00
210604	Урсгал засвар	500,000.00	1,600,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,344,234.00	1,215,000.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	1,344,234.00	1,215,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,987,571.93	58,001,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,359,971.93	46,742,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,627,600.00	11,258,900.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	20,053,100.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	20,053,100.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,478,067.94	1,299,877.14
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	99,463,813.91	107,382,239.14
	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	6,871,000.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(6,871,000.00)	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	92,592,813.91	107,382,239.14
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	611,404.03	93,204,217.94
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	93,204,217.94	200,586,457.08

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	<u>408,530,130.97</u>	<u>465,702,989.92</u>	<u>(61,792,660.93)</u>	<u>812,440,459.96</u>
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<u>408,530,130.97</u>	<u>465,702,989.92</u>	<u>(61,792,660.93)</u>	<u>812,440,459.96</u>
Тайлант үеийн үр дүн	-	-	111,494,839.60	111,494,839.60
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<u>408,530,130.97</u>	<u>465,702,989.92</u>	<u>1,567,815,678.34</u>	<u>2,442,048,799.23</u>
Тайлант үеийн үр дүн/Цэвэр ашиг алдагдал/	--	-	135,031,764.24	135,031,764.24
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	408,530,130.97	465,702,989.92	1,702,847,442.58	2,577,080,563.47

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
11000	Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл		93,204,217.94	(93,204,217.94)
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,228,650,300.00	1,028,063,960.86	200,586,339.14
21	УРСГАЛ ЗАРДАЛ			-
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	917,813,000.00	746,654,070.00	171,158,930.00
210101	Үндсэн цалин	666,779,500.00	508,024,603.00	158,754,897.00
210102	Нэмэгдэл	237,806,400.00	211,220,717.00	26,585,683.00
210104	Урамшуулал	13,227,100.00	27,408,750.00	(14,181,650.00)
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	105,504,800.00	92,914,790.86	12,590,009.14
210201	Тэтгэврийн даатгал	71,745,600.00	64,471,408.64	7,274,191.36
210202	Тэтгэмжийн даатгал	8,438,000.00	7,778,034.91	
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,220,100.00	3,761,969.37	458,130.63
210204	Ажилгүйдлийн даатгал	4,220,100.00	3,380,674.34	839,425.26
210205	Эрүүл мэндийн даатгал	16,881,000.00	13,522,703.60	3,358,296.40
2105	Нормативт зардал	138,702,800.00	129,278,600.00	9,424,200.00
210502	Хоол хүнс	138,702,800.00	129,278,600.00	9,424,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,794,200.00	1,215,000.00	2,579,200.00
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээ	3,794,200.00	1,215,000.00	2,579,200.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	62,835,500.00	58,001,500.00	4,834,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	51,576,600.00	46,742,600.00	4,834,000.00
	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,258,900.00	11,258,900.00	-

131001	Улсын төсвөөс санхүүжих	1,228,650,300.00	1,028,063,960.86	200,586,339.14
	Урьд оноос санхүүжих	93,204,100.00		93,204,100.00
	Гадаадын эх үүсвэрээс		500,000.00	
	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		93,204,217.94	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		200,586,457.08	
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	32.00	32.00	
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	
620002	Гүйцэтгэх ажилтан	21.00	21.00	
620003	Үйлчлэх ажилтан	10.00	10.00	

2.6 Аудит хийсэн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	37,066,400.00	35,766,522.86	1,299,877.14
21	УРСГАЛ ЗАРДАЛ	37,066,400.00	35,766,522.86	1,299,877.14
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	37,066,400.00	35,766,522.86	1,299,877.14
2103	БАЙР АШИГЛАЛТТАЙ ХОЛБООТОЙ ТОГТМОЛ ЗАРДАЛ	35,466,400.00	34,166,522.86	1,299,877.14
210301	Гэрэл, цахилгаан	7,173,800.00	6,699,414.84	474,385.16
21302	Түлш халаалт	19,744,800.00	18,872,186.02	872,613.98
21303	Цэвэр, бохир ус	8,547,800.00	8,594,922.00	(47,122.00)
	Урсгал засвар	1,600,000.00	1,600,000.00	
26	Төвлөрүүлэх шилжүүлэг		1,299,877.14	
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг		1,299,877.14	

2. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 151.8 сая төгрөгийн зөрчил¹ илэрснээс 1.5 сая төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 109.1 сая төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлэв.

2.1 Төлбөрийн акт

- НДШ-д код буруу оруулснаас ажилтнаас шимтгэлийг 0.2 сая төгрөгөөр илүү суутгаж авсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна.
- Төсвийн хөрөнгөөр байгууллагын ажилчид сургалтын үйл ажиллагаанд хамааралгүй сургалтад сууж 1.3 сая төгрөгийг байгууллагаас зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, 16.5.5-д Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах гэсэн заалтыг мөрдөөгүй нийцсэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2 Албан шаардлага

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

1. Үр дүнгийн урамшуулалтай давхардуулан балансын мөнгөн урамшууллыг нягтлан бодогч, нярав нар тус бүр 150.0 хувиар тооцон 3.8 сая төгрөгийг олгосон нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1 дэх "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.3 дахь "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэсэн заалтыг зөрчин Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор тогтоосон урамшууллын хэмжээг хэтрүүлэн олгосон, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
2. Тендерээр худалдан авалтын 105.3 сая төгрөгийн гэрээг буруу дүгнэж акт үйлдсэн нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 39 дугаар зүйлийн 39.3.2.гэрээний зүйл болон бараа, ажил, үйлчилгээний мэдээлэл, 48.2.9.энэ хуулийн 54.6-д заасан гүйцэтгэгчийн үүргийн гүйцэтгэлийг баталгаажуулах, мэдээллийн үнэн зөвийг хариуцах, 47.3.Бараа, ажил, үйлчилгээ хамтран худалдан авах төсвийн шууд захирагч тус тусын худалдан авах бараа, ажил, үйлчилгээний хувьд гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавина гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
НДШ-д код буруу оруулснаас ажилтнаас шимтгэлийг 0.2 сая төгрөгөөр илүү суутгаж авсан	1	185.4	1	185.4								
Төсвийн хөрөнгөөр байгууллагын ажилчид сургалтын үйл ажиллагаанд хамааралгүй сургалтад сууж 1.3 сая төгрөгийг байгууллагаас зарцуулсан	1	1,300.0	1	1,300.0								
Үр дүнгийн урамшуулалтай давхардуулан балансын мөнгөн урамшууллыг нягтлан бодогч, нярав нар тус бүр 150.0 хувиар тооцон 4.0 сая төгрөгийг олгосон	1	3,769.5			1	3,769.5						
Тендерээр худалдан авалтын гэрээг буруу дүгнэж акт үйлдсэн	1	105,313.3			1	105,313.3						
Дүн	4	110,568.2	2	1,485.4	2	109,082.8						



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 144/1962.5799
2025-02/44-144-СТА-2003

Чойбалсан хот

Г

Зөрчил арилгах тухай

Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэрлэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үйл ажиллагаа хариуцсан нягтлан бодогчид 1-1.5 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний 3,769,500.00 төгрөгийн мөнгөн урамшууллыг улирлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулан олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1. төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1. Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно: 15.1.3. хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр, тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох; Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2-д "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 дэх "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Зөрчлийг давтан гаргахгүй байх, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын дагуу урамшууллыг олгож байх, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх



2125040365

2. Засгийн газрын тогтоол, шийдвэрийг баримтлан ажиллахыг Хэрлэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч Г.Бадраа, нягтлан бодогч Л.Өнөржаргал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР  И.СЭМЖИДМАА

ХААН КОНСАЛТИНГ АУДИТ ХХК

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  Э.НАНДИНЧИМЭГ





ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 06 сарын 25 өдөр

Дугаар 145/199дсТЭГ
АВА-2025/МАТ/НА-СТН-ТМЗ

Чойбалсан хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэрлэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бараа, ажил, үйлчилгээг худалдан авах 105,313,300.00 төгрөгийн гэрээний хэрэгжилтийг дүгнэхдээ гэрээний үнэ болон нийлүүлэх бараа бүтээгдхүүний мэдээлэл, холбогдох нотлох баримтыг бүрдүүлээгүй байна.

Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх" зарчим, 39 дүгээр зүйлийн 39.3-т "Худалдан авах гэрээнд дараах нөхцөлийг тусгана", 39.3.1-д "гэрээний үнэ", 39.3.2-т "гэрээний зүйл болон бараа, ажил, үйлчилгээний мэдээлэл", 48 дугаар зүйлийн 48.2.7-т "Худалдан авах гэрээний хэрэгжилтэд тогтмол хяналт тавих, удирдлагаар хангах, хэрэгжилтийг цахим системд хөтлөх", 48.2.9-т "Энэ хуулийн 54.6-д заасан гүйцэтгэгчийн үүргийн гүйцэтгэлийг баталгаажуулах, мэдээллийн үнэн зөвийг хариуцах", 47.3-т "Бараа, ажил, үйлчилгээ хамтран худалдан авах төсвийн шууд захирагч тус тусын худалдан авах бараа, ажил, үйлчилгээний хувьд гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавина" гэсэн заалтуудыг зөрчиж байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.9 дэх "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" 4.2.1.11 дэх "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу хийж, худалдан авах гэрээнд тусгах нөхцлүүдийг бүрэн тусгасан байх холбогдох баримтыг бүрэн бүрдүүлэх, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2125040369

2. Хууль эрх зүйн шийдвэрийг баримтлан ажиллахыг Хэрлэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч Г.Бадраа, нягтлан бодогч Л.Өнөржаргал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР *Шүмэг* И.СЭМЖИДМАА

ХААН КОНСАЛТИНГ АУДИТ ХХК

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ *Э.Нандинчимэг* Э.НАНДИНЧИМЭГ





ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР
АКТ

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 50/19125799
дсд - 2025/145/НА - СМ - ТМЗ

Чойбалсан хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэрлэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус цэцэрлэгийн ажилтан Л.Батдэлгэрийн цалин хөлснөөс нийгмийн даатгалын шимтгэл 185,415.13 төгрөгийг илүү суутган байна.

Энэ нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/199 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг тайлагнах, шимтгэлийг нөхөн төлүүлэх журам”-ын 2.2.4-д “Нийгмийн даатгалын сангийн харилцах дансанд төлсөн шимтгэлийн дүн тухайн сарын тайланд тусгасан төлсөн шимтгэлийн дүнтэй тохирсон байх”, 2.2.6-д “Тайланд даатгуулагчийн төрөл, цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын хэмжээ, улсын кодыг үнэн зөв оруулсан байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-т “Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-д “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.”, Монгол Улсын Ерөнхий аудитормын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.3-т “цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон” гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. “Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг тайлагнах, шимтгэлийг нөхөн төлүүлэх журам” -ыг мөрддөггүй болон илүү суутган авсан 185,415.13 /нэг зуун наян таван мянга дөрвөн зуун арван таван төгрөг арван гурван/ мөнгийг ажилтан Л.Батдэлгэрт нөхөн олгох.

2125050222

2. Төлбөрийн актын биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Хэрлэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч Г.Бадраа, нягтлан бодогч Л.Өнөржаргал нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН

АУДИТЫН МЕНЕЖЕР



И.СЭМЖИДМАА

“ХААН КОНСАЛТИНГ АУДИТ” ХХК

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Э.НАНДИНЧИМЭГ





ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР
АКТ

2025 оны 06 сарын 25 өдөр

Дугаар 57/19125796
ОБЛА - АУДИТ / ТАС / НА - СТА - ТУУЗ

Чойбалсан хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэрлэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсвийн хөрөнгөөр цэцэрлэгийн албан хаагчид сургалтын үйл ажиллагаанд хамааралгүй сургалтанд сууж 1,300,000.00 төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-д “Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” шаардлага хангахгүй болон сургалтын төлбөрт төлсөн 1,300,000.00 /нэг сая гурван зуун мянган/ төгрөгийг Дорнод аймгийн Төрийн сан банкин дахь орон нутгийн хүү торгуулийн орлогын 100070000952 тоот дансанд төвлөрүүлэх.

3. Төлбөрийн актын биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Хэрлэн сумын 1 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч Г.Бадраа, нягтлан бодогч Л.Өнөржаргал нарт хариуцуулав.

2125050276

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН

АУДИТЫН МЕНЕЖЕР



И.СЭМЖИДМАА

“ХААН КОНСАЛТИНГ АУДИТ” ХХК

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Э.НАНДИНЧИМЭГ

